



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2009 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 509

Улаанбаатар хот

Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр  
суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 тоот тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Жадамбаа овогтой Эрдэнэтуяаг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Австралийн Мелбурн их сургуульд Боловсролын магистрантурт 1 жилийн хугацаатайгаар суралцуулсугай.

2. “Гадаадад зээлээр суралцуулах тухай” “Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 268 дугаар тушаалын Лхагвадоржийн Өнөртэй холбогдолтой хэсгийн “Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын York их сургуулийн” гэснийг “Америкийн Нэгдсэн Улсын Bridgeport их сургуулийн” гэж өөрчилсүгэй.

3. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



*Handwritten signature in blue ink.*

Ё.ОТГОНБАЯР